

*Харилцаа холбооны зохицуулах хорооны
2020 оны ... тоот тогтоолын хавсралт*

РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР НЭВТРҮҮЛЭХ ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь радио, телевизээр нэвтрүүлэх аливаа хэлбэрийн зар сурталчилгаанд тавих хязгаарлалт, шаардлагыг тодорхойлох болон зохицуулалт хийхэд оршино.

1.2 Радио, телевизээр зар сурталчилгааг нэвтрүүлэхэд үзэгч, хүүхдийн эрхийг хамгаалах, зар сурталчилгааны зохистой хэмжээг тогтоох, зах зээлийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, өргөн нэвтрүүлгийн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхэд зар сурталчилгааны зохицуулалтын зорилго оршино.

1.3 Радио, телевиз нь зар сурталчилгаа нэвтрүүлэхдээ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн баталсан дүрэм, журам болон энэхүү журмыг мөрдөж ажиллана.

1.4 Олон нийтийн радио, телевизийн үндсэн болон бусад сувгаар нэвтрүүлэх зар сурталчилгааг Олон нийтийн радио, телевизийн тухай хууль болон Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулна.

1.5 Радио, телевиз нь зар сурталчилгааг гэрээний үндсэн дээр нэвтрүүлнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ Радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны төрөл

2.1 Хөтөлбөрийн ивээн тэтгэлт, төлбөрт, захиалгат, теле-худалдааны нэвтрүүлэг нь зар сурталчилгаанд хамаарах бөгөөд зар сурталчилгаа нь дараах төрөлтэй байна.

2.1.1 Арилжааны зар сурталчилгаа;

2.1.1.а. Реклам;

2.1.1.б. Арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг;

2.1.1.в. Бүтээгдэхүүн байршуулалт;

2.1.1.г. Хөтөлбөрийн ивээн тэтгэлт;

2.1.2 Төлбөрт, захиалгат¹ нэвтрүүлэг;

2.1.3 Теле-худалдааны нэвтрүүлэг;

2.1.4 Нийгмийн зар сурталчилгаа.

¹ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4.1.13. “захиалгат нэвтрүүлэг” гэж радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид нэвтрүүлгийг бэлтгэх, дамжуулахаар хандсан хүсэлтийн дагуу бэлтгэсэн нэвтрүүлгийг;

2.2 Радио, телевизээр нэвтрүүлэх дараах сурталчилгаа, мэдээлэл нь зар сурталчилгаанд хамаарахгүй.

2.2.1 Радио, телевизийн өөрийн хөтөлбөр, нэвтрүүлгийн танилцуулга, сурталчилгаа;

2.2.2 Гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилан сэргийлэх зорилгоор эрх бүхий байгууллагын гаргасан гамшгийн зарлан мэдээлэл;²

2.3 Реклам гэдэгт нэвтрүүлэг хооронд эсхүл нэвтрүүлэг дундуур нэвтрүүлж буй богино хэмжээний арилжааны зар сурталчилгааг ойлгоно.

2.4 Арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг гэдэгт бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний сурталчилгааг мэдээллээр баяжуулж, онцлогийг тодотгож, ач холбогдол, зааврын талаар дэлгэрүүлж мэдээлэх хэлбэрээр бэлтгэсэн нэвтрүүлгийг ойлгоно.

2.5 Бүтээгдэхүүн байршуулалт гэж нэвтрүүлэгт бараа, бүтээгдэхүүнийг бодитоор нь эсхүл бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, барааны тэмдэг, уриа, лого, бичиглэл, дүрсийг байршуулах, хэрэглэж үзүүлэхийг ойлгоно.

2.6 Хөтөлбөрийн ивээн тэтгэлт гэж радио, телевизээр аливаа арга хэмжээ, кино, нэвтрүүлгийг бэлтгэн нэвтрүүлэхэд санхүүгийн болон бусад хэлбэрээр хандив, тусламж, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг ойлгоно.

2.7 Төлбөрт нэвтрүүлэг гэж тухайн радио, телевизийн редакцийн бодлогын хүрээнд бэлтгэгдээгүй, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төлбөртэй нэвтрүүлэх нөхцөлтэй бэлтгэн нэвтрүүлсэн нэвтрүүлгийг ойлгоно.

2.8 Теле худалдааны нэвтрүүлэг гэдэгт төрөл бүрийн бараа, бүтээгдэхүүнийг студид байрлуулан биетээр сурталчлан таниулж, хэрэглэх заавар, зөвлөгөөг тайлбарлан үзүүлж үзэгчдээс захиалга авч, хүргэх зорилгоор дэлгэрүүлэн мэдээлэх хэлбэрээр бэлтгэсэн сурталчилгааны нэвтрүүлгийг ойлгоно. Тухайн бараа, бүтээгдэхүүний онцлог, шинжээс хамаарч танилцуулгыг студид бус өөр орчин, нөхцөлд бэлтгэж болно.

2.9 Нийгмийн зар сурталчилгаанд нийтийн болон улс орны эрх ашигт нийцсэн ашиг тустай үйлс, үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээллэх, боловсрол олгох, дэмжих, тэтгэх зорилгоор бүтээсэн арилжааны бус зар сурталчилгааг ойлгоно.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Радио, телевизээр нэвтрүүлэх арилжааны зар сурталчилгааны хязгаарлалт

3.1 Радио, телевиз нь аливаа хэлбэрийн зар сурталчилгааг нэвтрүүлэхдээ Зар сурталчилгааны тухай хууль, холбогдох бусад хууль³ тогтоомжоор хориглосон, хууль бус зар сурталчилгааг нэвтрүүлэхгүй.

² Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.9. “гамшгийн зарлан мэдээлэл” гэж олон нийтэд хүргэх дохио, сэрэмжлүүлэх мэдээллийг;

³ Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хууль гм

3.2 Арилжааны телевизийн нэг цаг тутамд нэвтрүүлэх рекламны хугацаа 15 (арван тав) минутаас илүүгүй байна.

3.3 Өргөн нэвтрүүлгийн телевизийн нэг цаг тутамд нэвтрүүлэх рекламны хугацаа 12 (арван хоёр) минутаас илүүгүй байна.

3.4 Радио, телевизээр нэвтрүүлэх рекламны нэг блокны үргэлжлэх хугацаа таван минутаас илүүгүй байна.

3.5 Арилжааны радиогийн нэг цаг тутамд нэвтрүүлэх рекламны хугацаа 18 (арван найм) минутаас илүүгүй байна.

3.6 Нэг цаг гэдэгт тухайн цаг эхлэх минутын 00 секундээс дуусах сүүлийн минутын 59 секунд хүртэлх хугацааг ойлгоно.

3.7 Нэг цагт нэвтрүүлэх рекламны хугацааны хязгаарлалтад тухайн рекламны давталт хамаарна.

3.8 Зар сурталчилгааны эхлэл, төгсгөлийг илэрхийлэх дуу, дүрсэнд⁴ зар сурталчилгаа оруулсан тохиолдолд рекламны хугацааны хязгаарлалтад хамааруулж тооцно.

3.9 Текст (үгэн зар) хэлбэрээр нэвтрүүлсэн арилжааны зар сурталчилгааг рекламны хугацааны хязгаарлалтад оруулж тооцох ба Монгол хэлний зөв бичих дүрэм, хэм хэмжээнд⁵ нийцүүлэн урьдчилан боловсруулж, хөтөлбөрийн хуваарьт оруулсан байна.

3.10 Үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй.

3.11 Оргил цагаар (18:00-23:00) нэвтрүүлэх рекламны 80 хувь нь Монголд бүтээсэн реклам байна.

3.12 Радио, телевизээр хоногт нэвтрүүлэх арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг нь нийт хөтөлбөрийн цагийн 10 хувиас илүүгүй байх ба нэвтрүүлгийг хөтөлбөрийн хуваарьт оруулсан байна.

3.13 Хөтөлбөрийн цаг гэдгийг тухайн радио, телевизийн эфир эхэлсэн цагаас 24:00 цаг хүртэлх хугацааг ойлгоно.

3.14 Нэвтрүүлгийн үеэр бүтээгдэхүүн байршуулах зар сурталчилгаа нэвтрүүлэхдээ тухайн нэвтрүүлэгт саад учруулахгүйгээр, зохистой хэм хэмжээг баримтлан гаргах ба нэг нэвтрүүлэгт гураваас илүү бараа, бүтээгдэхүүн байршуулахгүй байна.

3.15 Цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг дундуур аливаа хэлбэрийн зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй бөгөөд

⁴ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 24.1

⁵ Монгол хэлний тухай хуулийн 19.1.1

нэвтрүүлгийн хугацааг тухайн нэвтрүүлэг эхлэх цагаас хөтөлбөрийн хуваарьт тусгасан дараагийн нэвтрүүлэг эхлэх цаг хүртэлх хугацаагаар тооцно.

3.16 Арилжааны зар сурталчилгаа нэвтрүүлэхээс бусад цагт нэвтрүүлж буй кино, нэвтрүүлгийн үеэр ивээн тэтгэгчийн болон аливаа бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зар сурталчилгааг баннер хэлбэрээр дэлгэц дээр давхардуулан гаргахгүй байна.

3.17 Баннер гэдэгт телевизийн дэлгэцийн буланд гарах хөдөлгөөнтэй эсвэл хөдөлгөөнгүй график дүрс, текстийг хамааруулж ойлгоно.

3.18 Харилцаа холбооны сүлжээ, дамжуулж байгаа технологиос үл хамааран үзэгчдээс ирүүлсэн чат, мессеж, нийгмийн сүлжээгээр дамжуулж байгаа зар сурталчилгаа, мессежийг нэвтрүүлэхгүй.

3.19 Гамшгаас хамгаалах тухай хууль, журам, зааварт⁶ тусгайлан заасан гамшгийн аюулын дуут дохиог гамшгийн зарлан мэдээллээс бусад зорилгоор зар сурталчилгаанд ашиглахгүй.

3.20 Радио, телевиз нь бараа бүтээгдэхүүнийг студид байрлуулж үнэ хаялцуулах, дуудлага худалдаа зохион байгуулах хэлбэрээр сурталчлан борлуулах нэвтрүүлэг нэвтрүүлэхгүй.

3.21 Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн нэг сарын нийт хөтөлбөрийн цагийн нэгээс багагүй хувийг нийгмийн зар сурталчилгаанд зарцуулна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаанд хүүхэд хамгаалах зорилгоор тавих хязгаарлалт

4.1 Хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлэхэд Зар сурталчилгааны тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

4.2 Хүүхдэд зориулсан кино, нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлж болно.

4.3 Хүүхдэд зориулсан кино, нэвтрүүлэг гэдэгт “Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох, таних тэмдэг ашиглах шаардлага” MNS 6587:2016 стандартад заасан балчир болон бага насны буюу 3+, 6+ насны хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг хамаарна.

4.4 Балчир насны буюу 3+ насны ангилалтай нэвтрүүлэг, киноны дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй.

4.5 Бага насны буюу 6+ насны ангилалтай нэвтрүүлэг, киноны дундуур нэвтрүүлэх зар сурталчилгааны хугацаа нь 30 минутын хугацаанд таван минутаас илүүгүй байна.

⁶ ОБЕГ-ын даргын 2019 оны А/68 тоот тушаалаар баталсан “Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх заавар” <http://nema.gov.mn/wp-content/uploads/2018/02/гамшгийн-аюулыг-зарлан-мэдээлэх-заавар.pdf>

4.6 Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур чихэр, давс, транс болон ханасан тос ихээр агуулсан хоол, хүнсний бүтээгдэхүүн⁷ сурталчлахгүй, бүтээгдэхүүн байршуулалт хийхгүй.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Радио, телевизээр нэвтрүүлэх хөтөлбөрийн ивээн тэтгэлт, төлбөрт, захиалгат нэвтрүүлэг, теле худалдааны нэвтрүүлгийн зохицуулалт

5.1 Нэвтрүүлгийн ивээн тэтгэгч, төлбөрт, захиалгат нэвтрүүлгийн эх сурвалжийг нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд болон нэвтрүүлгийн явцад дурдана.

5.2 Төлбөрт болон захиалгат нэвтрүүлэг нь тухайн нэвтрүүлгийн агуулгаас үл хамаарч “төлбөрт нэвтрүүлэг” эсхүл “захиалгат нэвтрүүлэг” гэсэн тэмдэглэгээтэй байх ба тэмдэглэгээг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичиж, телевизийн нэвтрүүлгийн нийт хугацааны турш гаргана. Радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд дурдана.

5.3 Теле худалдааны нэвтрүүлгийг зөвхөн теле худалдааны чиглэлээр төрөлжсөн арилжааны телевизээр нэвтрүүлнэ.

5.4 Теле худалдааны нэвтрүүлэг дундуур тухайн сурталчилж байгаа бараа, бүтээгдэхүүний техникийн үзүүлэлт, үнэ, үнийн хямдрал, захиалга авах утас зэрэг мэдээллийг агуулсан баннер гаргаж болно.

5.5 Теле худалдааны чиглэлээр төрөлжсөн телевизээр теле худалдааны нэвтрүүлгээс бусад төрлийн зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ

Зар сурталчилгаанд тавих хяналт

6.1 Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид Зохицуулах хороо гэх) нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 30 дугаар зүйлийн 30.1.8-ийн дагуу энэ журмын хэрэгжилтэд хяналт, мониторинг хийж ажиллана.

6.2 Радио, телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлсэн зар сурталчилгааны тайлан, мэдээллийг Зохицуулах хороонд хагас жил тутамд ирүүлнэ.

6.3 Зохицуулах хороо нь энэхүү журмыг зөрчсөн талаар гомдол ирсэн, хяналт мониторингийн дүнгээр зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох мэдээллийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын дагуу эрх бүхий байгууллагад шилжүүлж, холбогдох арга хэмжээг авна.

6.4 Зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон энэхүү журмын хүрээнд хийсэн мониторингийн дүн мэдээ, хяналт тавьж ажилласан талаарх тайланг олон нийтэд мэдээлж ажиллана.

---ooOoo---

⁷ Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолын хавсралт: Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр